



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 4/263

Номгон

Г Баянхонгор сумын Ерөнхий боловсролын
Эрдэнэмандал сургуулийн үйл ажиллагаанд
хяналт шалгалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.2.3 дахь заалт, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн сургалтын болон санхүүгийн үйл ажиллагаа, удирдлагын ёс зүй, холбогдох хууль, журам, стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээ авах ажлыг зохион байгуулсугай.

2.Хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх зорилгоор Аймгийн Засаг даргын Тамгын газар болон Боловсролын газрын хамтарсан ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

В.Наранчимэг

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Сарангарав

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль,
эрх зүйн хэлтсийн дарга

Л.Жаргалцэцэг

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын
дарга

О. Алтансүх

Боловсролын газрын Хөрөнгө оруулалт,
төсвийн гүйцэтгэл, хариуцсан ахлах
мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:


Л.Аюурзана

Боловсролын газрын дарга

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч
(Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА

Э.ЭНХБАТ



626010845